



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/629

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжлийн хэрэгцээ шаардлага, дуу хоолой, санал бодлыг сонсож, тэдний өмнө тулгамдсан асуудлыг шийдвэр гаргах түвшинд хүргэх, хүүхэд, залуучуудын асуудлаарх хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн хүүхдийн XII чуулганыг 2025 оны 03 дугаар сард зохион байгуулсугай.

2.Хөвсгөл аймгийн хүүхдийн XII чуулган зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Чуулганы удирдамж батлуулж, бэлтгэл ажлыг сайтар ханган, аймгийн Хүүхдийн зөвлөлийн оролцоотой зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Ч.Дашбаяр)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны....
дүгээр сарын....-ны өдрийн....-р
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ХҮҮХДИЙН XII ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Цэнд-Аюуш (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн
дарга)

Д.Мөнхжаргал (Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

М.Үүрийнбаяр (Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

О.Бадраа (Аймгийн Боловсролын газрын дарга)

Т.Раднаабүд (Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Л.Батцэцэг (Аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Б.Очирбат (Аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Ц.Оюун-Эрдэнэ (Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн
төвийн дарга)

Б.Мөнхнаран (Аймгийн Хүүхдийн зөвлөлийн дэд тэргүүн)

А.Сарангуа (Аймгийн Хүүхдийн зөвлөлийн нарийн бичиг)

Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Ч.Дашбаяр (Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)

_____оОо_____